



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02-адар

Дугаар 549

Улаанбаатар хот

Биет бус хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хот дахь Гаалийн газрын хөрөнгөд бүртгэлтэй, 21,144,140.00 (хорин нэгэн сая нэг зуун дөчин дөрвөн мянга нэг зуун дөчин) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (653 м.кв газар эзэмших эрх)-ийг Баянгол дүүргийн Татварын хэлтэст балансад шилжүүлсүгэй.

2. Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Баянгол дүүргийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ү.Амартувшин, Улаанбаатар хот дахь Гаалийн газрын орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Сүхбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Газар эзэмших, эрхийг шилжүүлэх асуудлыг нийслэлийн Засаг даргад хандан шийдвэрлүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*Д.Н.Дугаар*

Д.НАРАНГЭРЭЛ

132001478

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны  
өдрийн ~~12~~ дүгээр тогтоолын хавсралт

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Баянгол  
дүүргийн Татварын хэлтэст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжи х нэгж	Тоо хэмжээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1 дүгээр хороо)	2018	м.кв	653	21,144,140.00
	Нийт дүн				21,144,140.00 (хорин нэгэн сая нэг зуун дөчин дөрвөн мянга нэг зуун дөчин)